

Ажлын баримт: 3001

Хяналт шинжилгээ хийгдсэн нэгж:
НДЕГ болон түүний харьяа байгууллагууд



- ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН -

Аудитын нэр: Шилэн дансны цахим хуудасны мэдээлэл байршуулалтад хийсэн
хяналт шинжилгээний тайлан

Хамрах хугацаа: 2025/01/01-2025/03/31

2025 ОН

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙГДСЭН НЭГЖ:	НДЕГ болон түүний харьяа байгууллагууд
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙГДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА	Шилэн дансны цахим хуудасны мэдээлэл байршуулалт
ХАМРАХ ХУГАЦАА :	2025/01/01-2025/03/31
ГҮЙЦЭТГЭСЭН ХУГАЦАА:	2025/04/04-2025/04/16

ХЯНАСАН:	ГҮЙЦЭТГЭСЭН:
ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН ГАЗРЫН ДАРГА	ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

Б.ГАНХУЯГ

Н.БОЛОРМАА

Э.ЦОЛМОН

Д.ОЮУНТУЯА

Ц.ҮЗМЭЭ

Ж.МӨНХЗУЛ

АГУУЛГА

1. ҮНДЭСЛЭЛ

2. ЗОРИЛГО

3. ХАМРАХ ХҮРЭЭ

4. АРГА АРГАЧЛАЛ, ТАЙЛАНТ УЛИРАЛД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЛААР

5. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

5.1. Сан

5.2. Үйл ажиллагаа

6. ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДАЛ

7. АВСАН АРГА ХЭМЖЭЭ, ӨГСӨН ЗӨВЛӨМЖ

8. ДҮГНЭЛТ

9. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. ҮНДЭСЛЭЛ

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16.5.6 дахь хэсэг, Шилэн дансны тухай хууль, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 03 дугаар албан даалгавар, Дотоод аудит, мониторингийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэв.

2. ЗОРИЛГО

Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, шилэн дансны цахим хуудасны 2025 оны 01 дүгээр улирлын байдлаарх шилэн дансны хөтлөлт, мэдээлэл байршуулалт, холбогдох баримт бичгийг бүрэн оруулсан байдалд хяналт хийж, илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулахад гол зорилго оршино.

3. ХАМРАХ ХҮРЭЭ

Нийгмийн даатгалын ерөнхий газар, Мэдээллийн технологийн төв, БНСУ дахь ХНХҮ-ний төвийн Нийгмийн даатгалын тасаг, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын байгууллагын үйл ажиллагааны болон нийгмийн даатгалын сангийн мэдээллийг шилэн дансны цахим хуудас (shilendans.gov.mn)-т хуулийн хугацаанд үнэн зөв, бодитой мэдээлсэн эсэхийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацааг хамрууллаа.

4. АРГА АРГАЧЛАЛ, ТАЙЛАНТ УЛИРАЛД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЛААР

4.1. АРГА АРГАЧЛАЛ

Хяналт шинжилгээг гүйцэтгэхэд шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийг харилцах дансдын хуулга, мөнгөн хөрөнгө зарцуулах тухай А, Б тушаал, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, батлагдсан төсөв, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, холбогдох сарын мэдээ зэрэгт үндэслэн хяналт хийж, байршуулсан мэдээ, мэдээллийг баримтаар тулган шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах зэрэг арга зүйг ашиглан нотлох баримт цуглуулж хэрэгжүүллээ.

Хяналт шинжилгээг хэрэгжүүлэхэд дараах хууль эрх зүйн баримт бичгийг эх үүсвэр болгон ашиглалаа. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хууль;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль;
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”;
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хуваарь батлах тухай” А/01 дүгээр тушаал, 2025 оны “Нийгмийн

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

- даатгалын сангийн 2025 оны төсвийн хуваарийг өөрчлөн батлах тухай” А/15, А/50 дугаар тушаал;
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны төсвийн хуваарь батлах тухай” А/02 дугаар тушаал, 2025 оны “Үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” А/16, А/49 дүгээр тушаал;
 - Бусад холбогдох хууль, дүрэм, журам;

4.2. ТАЙЛАНТ УЛИРАЛД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ

Тайлант хугацаанд шилэн дансны мэдээлэл байршуулалттай холбоотой дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Шилэн дансны хөтлөлтийн 2024 оны 4 дүгээр улирлын тайланг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэх;

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 8.1-т зааснаар Нийгмийн даатгалын харьяа байгууллагуудын 2024 оны 4 дүгээр улирлын байдлаарх шилэн дансны хөтлөлтийн тайланг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэлд үндэслэн хяналт тавьж нэгтгэлийг хийв.

Тус нэгтгэлийг дараах байдлаар гаргав. Үүнд:

- Нийгмийн даатгалын байгууллагын санхүү, үйл ажиллагааны мэдээлэл байршуулалт;
- Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл байршуулалт;
- Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын нийт мэдээлэл байршуулалт;

2024 оны 4 дүгээр улирлын шилэн дансны хөтлөлтийг харуулбал:

Мэдээлэл байршуулалт	Нийт	Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа	Нийгмийн даатгалын сан
Мэдээлэл байршуулах нэгжийн тоо	67	34	33
Нийт мэдээлэл	11,199	5,962	5,237
Хугацаандаа оруулсан мэдээлэл	11,079	5,897	5,182
Хугацаа хоцорсон мэдээлэл	120	65	55
Оруулаагүй мэдээлэл	0	0	0
Нийт мэдээлэл байршуулсан хувь	100%	100%	100%
Хугацаандаа мэдээлэл байршуулсан хувь	99%	99%	99%

Нийгмийн даатгалын байгууллагууд нийт 24 төрлийн 11,199 мэдээллийг байршуулахаас хугацаандаа байршуулсан мэдээлэл 11,079 хугацаа хоцроосон 120 мэдээлэл байсан ба мэдээлэл байршуулалт 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар 100 хувь, хугацаандаа мэдээлэл байршуулалт 99 хувьтай байна.

Шилэн дансны хөтлөлтийн 2024 оны 4 дүгээр улирлын нэгдсэн тайлан /Мэдээлэл байршуулалт/-г Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/81 дүгээр албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

- *Шилэн дансны мэдээлэл байршуулалттай холбоотой зөвлөмжийг нэгжийн дарга нарт хүргүүлэх;*

Шилэн дансны тухай хууль холбогдох журмын хэрэгжилтэд Нийгмийн даатгалын ерөнхий газар болон харьяа газруудад 2024 оны эхний 9 сарын сарын байдлаар 2024 оны 4 дүгээр улиралд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх, дотоод хяналтыг сайжруулж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах талаарх зөвлөмжийг Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны “Шилэн дансны зөвлөмж хүргүүлэх тухай” 02/262 дугаар албан бичгээр Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт хүргүүлсэн.

- *Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 03 дугаар албан даалгаврыг нэгжүүдэд хүргүүлэх:*

Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын 2025 оны 07/676 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны “Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах тухай” 03 дугаар албан даалгаврыг ирүүлсэн.

Дээрх албан даалгаварт тусгагдсан үүрэг даалгаврыг заалт нэг бүрчлэн биелүүлж ажиллахыг Дотоод аудит, мониторингийн газрын 2025 оны “Албан даалгавар хүргүүлэх тухай” 02/529 дүгээр албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар, Мэдээллийн технологийн төв, БНСУ дахь ХНХҮ-ний төвийн Нийгмийн даатгалын тасгийн дарга нарт үүрэг болгосон.

Дээрх албан бичигт дурдагдсаны дагуу Шилэн дансны цахим хуудас дахь мэдээлэл байршуулалтад сар бүр хяналт хийсэн тухай тайланг Төв, Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар хугацаа хоцроож ирүүлсэн бөгөөд бусад аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрууд ирүүлээгүй байна.

- *Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага, зөвлөмж авсан газруудад хариуцлага тооцох тухай албан бичгийг хүргүүлэх;*

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 571.7 сая төгрөгийн 5 албан шаардлага, 439.3 сая төгрөгийн 6 зөвлөмж авсан Баянгол, Багануур, Налайх, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг, Баян-Өлгий, Говьсүмбэр, Төв аймгийн Нийгмийн даатгалын газарт Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Шилэн дансны мэдээлэл байршуулах тухай” 01/755, 01/757 01/756, 01/760, 01/753, 01/758, 01/754, 01/752 01/759 дүгээр албан бичгийг тус тус хүргүүлэв.

5. ҮР ДҮН

Хяналт шинжилгээгээр Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Мэдээллийн технологийн төв, БНСУ дахь ХНХҮ-ний төвийн Нийгмийн даатгалын тасаг, 21 аймаг, 9 дүүргийн Нийгмийн даатгалын газруудын байгууллагын үйл ажиллагаа болон нийгмийн даатгалын сангийн мэдээллийг шилэн дансны цахим хуудас (shilendans.gov.mn)-т байршуулсан байдлыг холбогдох баримттай тулган шалгалаа.

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оны эхний 03 сарын байдлаар шилэн дансны цахим хуудсанд Нийгмийн даатгалын байгууллагын болон нийгмийн даатгалын сангийн нийт 58,567 шийдвэр гүйлгээний 58,845,646.6 сая төгрөгийн 2,851 мэдээлэл байршуулахаас 2,567 мэдээллийг хугацаанд мэдээлж мэдээлэл байршуулалт 96 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 90 хувьтай байна.

Хугацаандаа мэдээлсэн 2,567 мэдээллийн:

- Хугацаандаа мэдээлсэн 1,014 мэдээлэл;
- “Оруулах мэдээлэл байхгүй” төлөвөөр мэдээлсэн 1,552 мэдээлэл;
- Араас нь хугацаандаа зассан 1 мэдээлэл байна.

Мэдээлэл байршуулалтыг аймаг, дүүргээр харуулбал:

/сая төгрөг/

Д/д		Нийт мэдээлэл	Мэдээлэл зохих		Мэдээлэл хугацаандаа оруулсан	Хугацаа хоцорсон	Үүнээс:		Мэдээлэл оруулаагүй	Үүнээс:		Нийт мэдээлэл байршуулсан	Хугацаа даа мэдээлэл байршуулсан
			Шийдвэр, гүйлгээний тоо	Мөнгөн дүн			Шийдвэр, гүйлгээний тоо	Хугацаа хоцроосон мөнгөн дүн		Шийдвэр, гүйлгээний тоо	Мэдээлэлгүй мөнгөн дүн		
1	Архангай НДГ	89	955	679,816.5	85	3	5	177.4	1	3	3,599.3	99%	96%
2	Баян-Өлгий НДГ	89	989	615,543.2	76	10	594	62,041.9	3	13	218,559.9	97%	85%
3	Баянхонгор НДГ	89	1,081	699,956.1	73	7	38	20,628.2	9	9	583,772.0	90%	82%
4	Булган НДГ	89	789	494,422.5	76	10	43	183,373.4	3	18	179,476.5	97%	85%
5	Говь-Алтай НДГ	89	782	323,897.6	78	7	194	139,499.0	4	4	22.8	96%	88%
6	Говьсүмбэр НДГ	89	531	190,278.6	86	3	19	3,862.9	-	2	1.1	100%	97%
7	Дархан-Уул НДГ	89	1,408	1,119,355.3	86	2	8	2,066.3	1	7	357,130.5	99%	97%
8	Дорноговь НДГ	89	1,281	770,673.0	85	4	92	4,409.2	2	2	461,618.0	98%	96%
9	Дорнод НДГ	89	1,127	698,829.3	80	5	727	83,377.6	4	93	242,895.3	96%	90%
10	Дундговь НДГ	89	532	373,531.6	84	4	395	42,783.0	1	2	125,111.9	99%	94%
11	Завхан НДГ	89	999	673,663.9	86	3	729	208,816.4	-	-	-	100%	97%
12	Орхон НДГ	89	1,008	1,429,139.7	78	11	39	8,108.4	-	-	-	100%	88%
13	Өвөрхангай НДГ	89	1,271	963,796.9	84	5	238	26,341.4	-	4	2,203.1	100%	94%
14	Өмнөговь НДГ	89	1,710	1,010,701.2	85	1	2	352,340.9	3	8	373,501.0	97%	96%
15	Сүхбаатар НДГ	89	1,577	391,010.9	75	8	61	22,914.3	6	19	17.5	93%	84%
16	Сэлэнгэ НДГ	89	1,219	858,846.8	69	5	564	25,999.8	15	82	332,023.4	83%	78%
17	Төв НДГ	89	1,113	752,566.4	73	16	95	260,732.7	-	-	-	100%	82%
18	Увс НДГ	89	1,057	561,981.0	83	6	263	8,487.4	-	17	459.8	100%	93%
19	Ховд НДГ	89	1,203	699,858.1	73	6	7	41.4	10	11	28,934.5	89%	82%
20	Хөвсгөл НДГ	89	1,385	837,418.7	72	8	923	106,795.4	9	353	398,620.2	90%	81%
21	Хэнтий НДГ	89	1,223	631,880.8	81	8	5	1,847.3	-	-	-	100%	91%
22	Багануур НДГ	89	490	314,241.8	86	-	29	2,184.5	3	5	15.6	97%	97%
23	Багахангай НДГ	89	178	42,432.3	79	10	10	14,015.4	-	-	-	100%	89%
24	Баянгол НДГ	89	5,847	3,622,150.2	83	5	18	9,045.3	1	350	121,054.0	99%	93%
25	Баянзүрх НДГ	89	4,668	3,573,419.4	82	4	9	300.5	3	-	-	97%	92%
26	Налайх НДГ	89	310	389,186.3	72	12	106	24,114.5	5	12	136,316.0	94%	81%
27	Сонгинохайрхан НДГ	89	2,791	2,277,645.0	86	2	38	23.6	1	6	17,222.3	99%	97%
28	Сүхбаатар дүүргийн НДГ	89	5,013	2,958,547.8	85	1	5	2.7	3	23	767.0	97%	96%
29	Хан-Уул НДГ	89	4,693	3,114,107.7	89	-	-	-	-	-	13,217.0	100%	100%
30	Чингэлтэй НДГ	89	4,353	3,126,632.3	72	11	622	69,262.2	6	615	64,224.0	93%	81%
31	БНСУ дахь ХНХУ-ний төвийн НД-ын тасаг	43	8	936.6	41	1	1	9.2	1	7	927.5	98%	95%
32	НДЕГ-МТТөв	46	44	9,777.9	44	1	1	645.3	1	-	-	98%	96%
33	НДЕГ төв сан	92	6,932	24,639,401.2	80	6	19	986,298.5	6	990	13,084,842.0	93%	87%
НИЙТ		2,851	58,567	58,845,645.6	2,567	183	5,899	2,670,545.9	101	2,655	16,746,532.2	96%	90%

Хяналт шинжилгээгээр нийт 22,260,030.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс:

- 2,655 шийдвэр гүйлгээний 16,746,532.2 сая төгрөгийн 101 мэдээллийг мэдээлээгүй;
- 1,311 шийдвэр гүйлгээний 2,842,952.6 сая төгрөгийн мэдээллийг илүү мэдээлсэн;

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

- 5,899 шийдвэр гүйлгээний 2,670,545.9 сая төгрөгийн 183 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн ба хяналт шинжилгээний явцад зөрчлийг залруулж нөхөн мэдээлсэн 2,623 шийдвэр гүйлгээний 1,236,818.3 сая төгрөгийн мэдээлэл байна.

Мэдээлээгүй, мөн дутуу мэдээлсэн 19,417,078.1 сая төгрөгийн 284 мэдээлэл байгаа бөгөөд энэ нь нийт мэдээллийн 10.0 хувийг эзэлж байна.

5.1. Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл байршуулалт:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийгмийн даатгалын сангийн 32 хэрэглэгчээр шилэн дансны цахим хуудас (shilendans.gov.mn)-т Нийгмийн даатгалын сангийн Төсөв, гүйцэтгэл төрөлд 6, Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт төрөлд 5, Бусад төрөлд 6 нийт 17 төрлийн мэдээллийг байршуулан хэрэглэгчид нийгмийн даатгалын байгууллагын болон нийгмийн даатгалын сангийн мэдээлэлтэй танилцах боломжийг ханган ажиллаж байна.

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оны эхний 03 сарын байдлаар шилэн дансны цахим хуудсанд Нийгмийн даатгалын сангийн нийт 57,297 шийдвэр гүйлгээний 58,623,128.9 сая төгрөгийн 1,379 мэдээлэл байршуулахаас 1,288 мэдээллийг хугацаанд нь мэдээлж мэдээлэл байршуулалт 97 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 93 хувьтай байна.

Мэдээлэл байршуулалтыг аймаг, дүүргээр харуулбал:

/сая төгрөг/

Д/д		Нийт мэдээлэх	Мэдээлэл зохих		Мэдээлэл хугацаандаа оруулсан	Хугацаа хоцорсон мэдээлэл	Үүнээс:		Мэдээлэл оруулаагүй	Үүнээс:		Нийт мэдээлэл байршуулсан	Хуудсанд мэдээлэл байршуулсан
			Шийдвэр, гүйлгээний тоо	Мөнгөн дүн			Шийдвэр, гүйлгээний тоо	Хугацаа хоцорсон мөнгөн дүн		Шийдвэр, гүйлгээний тоо	Мэдээлээгүй мөнгөн дүн		
1	Архангай НДГ	43	916	674,010.0	43	-	-	-	-	-	3,595.0	100%	100%
2	Баян-Өлгий НДГ	43	959	610,411.5	37	4	585	61,944.1	2	9	216,670.8	95%	86%
3	Баянхонгор НДГ	43	1,027	692,723.5	34	-	10	18,760.0	9	9	583,772.0	79%	79%
4	Булган НДГ	43	761	489,839.0	40	3	19	179,476.5	-	18	179,476.5	100%	93%
5	Говь-Алтай НДГ	43	737	317,826.8	38	5	186	137,651.3	-	-	-	100%	88%
6	Говьсүмбэр НДГ	43	491	187,628.7	43	-	15	2,984.0	-	-	-	100%	100%
7	Дархан-Уул НДГ	43	1,379	1,113,152.1	42	-	-	-	1	1	357,118.5	98%	98%
8	Дорноговь НДГ	43	1,222	765,242.4	41	-	89	4,358.0	2	2	461,618.0	95%	95%
9	Дорнод НДГ	43	1,085	692,688.3	37	4	727	83,377.6	2	89	240,976.2	95%	86%
10	Дундговь НДГ	43	506	368,449.5	38	4	395	42,783.0	1	2	125,111.9	98%	88%
11	Завхан НДГ	43	972	667,067.9	40	3	727	208,793.2	-	-	-	100%	93%
12	Орхон НДГ	43	970	1,424,192.7	41	2	22	4,036.3	-	-	-	100%	95%
13	Өвөрхангай НДГ	43	1,225	958,858.2	42	1	233	26,289.2	-	-	-	100%	98%
14	Өмнөговь НДГ	43	1,671	1,005,107.8	41	1	1	352,335.1	1	1	373,483.2	98%	95%
15	Сүхбаатар НДГ	43	1,529	386,001.7	42	1	47	22,517.8	-	-	-	100%	98%
16	Сэлэнгэ НДГ	43	1,160	851,530.2	38	2	559	25,750.3	3	71	328,332.8	93%	88%
17	Төв НДГ	43	1,077	746,608.4	41	2	66	257,879.1	-	-	-	100%	95%
18	Увс НДГ	43	1,024	555,677.9	42	1	246	8,027.6	-	-	-	100%	98%
19	Ховд НДГ	43	1,170	693,717.3	41	-	-	-	2	-	27,549.0	95%	95%
20	Хөвсгөл НДГ	43	1,336	829,714.8	35	4	917	106,753.3	4	343	395,866.9	91%	81%
21	Хэнтий НДГ	43	1,194	627,063.1	43	-	-	-	-	-	-	100%	100%
22	Багануур НДГ	43	464	311,140.1	43	-	29	2,184.5	-	-	-	100%	100%
23	Багахангай НДГ	43	153	41,621.2	40	3	3	13,635.9	-	-	-	100%	93%
24	Баянгол НДГ	43	5,821	3,614,155.2	42	-	11	6,509.0	1	350	121,054.0	98%	98%
25	Баянзүрх НДГ	43	4,632	3,562,840.9	43	-	-	-	-	-	-	100%	100%
26	Налайх НДГ	43	292	385,716.2	37	2	96	22,241.9	4	12	136,316.0	91%	86%
27	Сонгинохайрхан НДГ	43	2,689	2,268,280.7	42	-	-	-	1	6	17,222.3	98%	98%
28	Сүхбаатар дүүргийн НДГ	43	4,974	2,949,710.6	43	-	-	-	-	-	556.4	100%	100%
29	Хан-Уул НДГ	43	4,663	3,106,008.0	43	-	-	-	-	-	13,217.0	100%	100%
30	Чингэлтэй НДГ	43	4,303	3,120,688.2	37	-	612	64,223.2	6	612	64,223.2	86%	86%
31	БНСУ дахь ХНХУ-ний төвийн тасаг НД-ын тасаг	43	8	936.6	41	1	1	9.2	1	7	927.5	98%	95%
32	НДЕГ төв сан	46	6,887	24,604,519.3	38	3	6	972,398.0	5	984	13,084,720.4	89%	83%
		1,379	57,297	58,623,128.9	1,288	46	5,602	2,624,918.0	45	2,516	16,731,807.5	97%	93%

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Хяналт шинжилгээгээр нийт 22,111,852.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс:

- 2,516 шийдвэр гүйлгээний 16,731,807.5 сая төгрөгийн 45 мэдээллийг мэдээлээгүй;
- 215 шийдвэр гүйлгээний 2,755,126.7 сая төгрөгийн мэдээллийг илүү мэдээлсэн;
- 5,602 шийдвэр гүйлгээний 2,624,918.0 сая төгрөгийн 46 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн ба хяналт шинжилгээний явцад зөрчлийг залруулж нөхөн мэдээлсэн 2,418 шийдвэр гүйлгээний 1,216,879.8 сая төгрөгийн мэдээлэл байна.

Мэдээлээгүй, мөн дутуу мэдээлсэн 19,356,725.6 сая төгрөгийн 91 мэдээлэл байгаа бөгөөд энэ нь нийт мэдээллийн 7.0 хувийг эзэлж байна.

Дээрх хүснэгтээс харахад: Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрууд 1,379 мэдээлэл мэдээлэхээс Баян-Өлгий аймаг 2, Баянхонгор аймаг 9, Дорнод аймаг 2, Сэлэнгэ аймаг 3, Хөвсгөл аймаг 4, Налайх дүүрэг 4, Чингэлтэй дүүрэг 6, Нийгмийн даатгалын ерөнхий газрын төв сан 5 мэдээлэл мэдээлээгүй, Баян-Өлгий аймаг 4, Говь-Алтай аймаг 5, Дорнод аймаг 4, Дундговь аймаг 4, Сэлэнгэ аймаг 2, Хөвсгөл аймаг 4, Налайх дүүрэг 2, Нийгмийн даатгалын ерөнхий газрын төв сан 3 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн нь нийт мэдээллийн 4.6 хувийг эзэлж байна.

Мэдээлээгүй буюу цахим хуудсанд байршуулаагүй мэдээллийг мэдээллийн *төрлөөр* нь авч үзвэл:

/сая төгрөг/

№	Шилэн дансны мэдээллийн төрлийн нэр	Нийт мэдээлэх	Мэдээлэл зохих		Мэдээлэл хугацаандаа оруулсан	Хугацаа хоцорсон мэдээлэл	Үүнээс:		Мэдээлэл оруулаагүй	Үүнээс:		Нийт мэдээлэл байршуулсан хувь	Хугацаандаа мэдээлэл байршуулсан хувь
			Шийдвэр, гүйлгээний тоо	Мөнгөн дүн			Шийдвэр, гүйлгээний тоо	Хугацаа хоцроосон мөнгөн дүн		Шийдвэр, гүйлгээний тоо	Мэдээлэл үй мөнгөн дүн		
1	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-Эдийн засгийн ангилал	96	93	2,264,052.5	91	2	2	14,366.0	3	6	33,959.2	97%	95%
2	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл-Хөтөлбөр, зориулалт	96	94	2,264,052.5	89	1	1	8,091.9	6	9	68,681.3	94%	93%
3	Байгууллагын батлагдсан төсөв	32	35	16,135,829.9	28	2	3	360,261.5	2	2	135,117.1	94%	88%
4	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	96	42,684	5,988,790.7	71	21	4,236	367,502.2	4	1,351	980,194.1	96%	74%
5	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	96	14,321	5,467,800.8	72	15	1,350	248,652.4	9	1,129	749,267.9	91%	75%
6	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	96	51	25,051,386.8	75	2	4	653,646.1	19	19	14,764,588.0	80%	78%
ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛ		512	57,278	57,171,913.2	426	43	5,596	1,652,520.0	43	2,516	16,731,807.5	92%	83%
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	32	4	7,184.0	31	1	4	7,184.0	0	-	-	100%	97%
2	Худалдан авах ажиллагааны тайлан /2024 он/	32	4	238.0	32	0	-	-	0	-	-	100%	100%
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТЕНДЕР, ХУДАЛДАН		288	8	7,422.0	287	1	4	7,184.0	0	-	-	100%	100%

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

АВАЛТ													
1	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	96	8	377.7	94	0	-	-	2	-	-	98%	98%
2	Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн талаарх мэдээлэл**	3	3	1,443,416.0	1	2	2	965,214.0	0	-	-	100%	33%
БУСАД		579	11	1,443,793.7	575	2	2	965,214.0	2	-	-	100%	99%
НИЙТ		1,379	57,297	58,623,128.9	1,288	46	5,602	2,624,918.0	45	2,516	16,731,807.5	97%	93%

Дээрх хүснэгтээс харахад: Нийт мэдээлээгүй буюу хугацаа хоцроосон мэдээллийн 94.5 хувь буюу 86 мэдээлэл нь **Төсөв, гүйцэтгэл** төрөлд, 1.1 хувь буюу 1 мэдээлэл нь **Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт** төрөлд, 4.4 хувь буюу 4 мэдээлэл нь **Бусад** төрөлд мэдээллийг мэдээлээгүй буюу хугацаа хоцроосон байна.

Төсөв, гүйцэтгэл төрөлд хугацаандаа байршуулсан мэдээлэл 74-78 хувь;
Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт төрөлд хугацаандаа байршуулсан мэдээлэл 100 хувь;
Бусад төрөлд хугацаандаа байршуулсан мэдээлэл 33-98 хувьтай байна.

5.2. Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл байршуулалт

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын харьяа 32 байгууллага 32 хэрэглэгчээр шилэн дансны цахим хуудас (shilendans.gov.mn)-т Нийгмийн даатгалын байгууллагын **Төсөв, гүйцэтгэл** төрөлд 6, **Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт** төрөлд 6, **Бусад** төрөлд 6, нийт 18 төрлийн мэдээллийг байршуулан хэрэглэгчид нийгмийн даатгалын байгууллагын болон нийгмийн даатгалын сангийн мэдээлэлтэй танилцах боломжийг ханган ажиллаж байна.

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оны эхний 03 сарын байдлаар шилэн дансны цахим хуудсанд Нийгмийн даатгалын байгууллагын нийт 1,270 шийдвэр гүйлгээний 222,516,774.5 мянган төгрөгийн 1,472 мэдээлэл байршуулахаас 1,279 мэдээллийг хугацаанд нь мэдээлж мэдээлэл байршуулалт 96 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 87 хувьтай байна.

Мэдээлэл байршуулалтыг аймаг, дүүргээр харуулбал:

/мян. төгрөг/

Д/д		Нийт мэдээлэх	Мэдээлвэл зохих		Мэдээлэл хугацаандаа оруулсан	Хугацаа хоцорсон мэдээлэл	Үүнээс:		Мэдээлэл оруулаагүй	Үүнээс:		Нийт мэдээлэл байршуулсан хувь	Хугацаандаа мэдээлэл байршуулсан хувь
			Шийдвэр, гүйлгээний тоо	Мөнгөн дүн			Шийдвэр, гүйлгээний тоо	Хугацаа хоцроосон мөнгөн дүн		Шийдвэр, гүйлгээний тоо	Мэдээлээгүй мөнгөн дүн		
1	Архангай НДХ	46	39	5,805,488.4	42	3	5	177,366.1	1	3	4,243.9	98%	91%
2	Баян-Өлгий НДХ	46	30	5,131,695.5	39	6	9	97,765.6	1	4	1,889,141.4	98%	85%
3	Баянхонгор НДХ	46	54	7,232,581.0	39	7	28	1,868,206.0	-	-	-	100%	85%
4	Булган НДХ	46	28	4,583,448.1	36	7	24	3,896,931.9	3	-	-	93%	78%
5	Говь-Алтай НДХ	46	45	6,070,752.2	40	2	8	1,847,669.4	4	4	22,831.4	91%	87%

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

6	Говьсүмбэр НДХ	46	40	2,649,916.4	43	3	4	878,892.3	-	2	1,061.3	100%	93%
7	Дархан-Уул НДХ	46	29	6,203,221.6	44	2	8	2,066,314.5	-	6	12,094.0	100%	96%
8	Дорноговь НДХ	46	59	5,430,618.7	44	2	3	51,169.8	-	-	-	100%	96%
9	Дорнод НДХ	46	42	6,141,045.9	43	1	-	-	2	4	1,919,094.9	96%	93%
10	Дундговь НДХ	46	26	5,082,090.5	46	-	-	-	-	-	-	100%	100%
11	Завхан НДХ	46	27	6,595,994.2	46	-	2	23,242.3	-	-	-	100%	100%
12	Орхон НДХ	46	38	4,946,951.7	37	9	17	4,072,083.4	-	-	-	100%	80%
13	Өвөрхангай НДХ	46	46	4,938,664.8	42	4	5	52,237.0	-	4	2,203,086.3	100%	91%
14	Өмнөговь НДХ	46	39	5,593,331.1	44	-	1	5,868.7	2	7	17,863.6	96%	96%
15	Сүхбаатар НДХ	46	48	5,009,176.3	33	7	14	396,509.1	6	19	17,475.1	87%	72%
16	Сэлэнгэ НДХ	46	59	7,316,611.4	31	3	5	249,523.1	12	11	3,690,646.5	74%	67%
17	Төв НДХ	46	36	5,958,036.4	32	14	29	2,853,532.7	-	-	-	100%	70%
18	Увс НДХ	46	33	6,303,164.2	41	5	17	459,778.3	-	17	459,778.3	100%	89%
19	Ховд НДХ	46	33	6,140,790.3	32	6	7	41,383.0	8	11	1,385,453.8	83%	70%
20	Хөвсгөл НДХ	46	49	7,703,888.3	37	4	6	42,143.1	5	10	2,753,265.7	89%	80%
21	Хэнтий НДХ	46	29	4,817,649.5	38	8	5	1,847,267.1	-	-	-	100%	83%
22	Багануур НДХ	46	26	3,101,682.0	43	-	-	-	3	5	15,633.8	93%	93%
23	Багахангай НДХ	46	25	811,052.2	39	7	7	379,467.9	-	-	-	100%	85%
24	Баянгол НДХ	46	26	7,995,202.1	41	5	7	2,536,273.4	-	-	-	100%	89%
25	Баянзүрх НДХ	46	36	10,578,535.9	39	4	9	300,486.4	3	-	-	93%	85%
26	Налайх НДХ	46	18	3,470,132.0	35	10	10	1,872,632.6	1	-	-	98%	76%
27	Сонгинохайрхан НДХ	46	102	9,364,336.1	44	2	38	23,612.7	-	-	-	100%	96%
28	Сүхбаатар дүүргийн НДХ	46	39	8,837,134.1	42	1	5	2,690.0	3	23	210,598.7	93%	91%
29	Хан-Уул НДХ	46	30	8,099,714.7	46	-	-	-	-	-	-	100%	100%
30	Чингэлтэй НДХ	46	50	5,944,026.0	35	11	10	5,038,980.3	-	3	794.0	100%	76%
31	НДЕГ-МТТ	46	44	9,777,945.8	44	1	1	645,323.2	1	-	-	98%	96%
32	НДЕГ	46	45	34,881,897.0	42	3	13	13,900,521.4	1	6	121,644.2	98%	91%
		1,472	1,270	222,516,774.5	1,279	137	297	45,627,871.4	56	139	14,724,706.8	96%	87%

Хяналт шинжилгээгээр нийт 148,178,545.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс:

- 139 шийдвэр гүйлгээний 14,724,706.8 мянган төгрөгийн 56 мэдээллийг мэдээлээгүй;
- 1,096 шийдвэр гүйлгээний 87,825,967.5 мянган төгрөгийн мэдээллийг илүү мэдээлсэн;
- 297 шийдвэр гүйлгээний 45,627,871.4 мянган төгрөгийн 137 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн ба хяналт шинжилгээний явцад зөрчлийг залруулж нөхөн мэдээлсэн 205 шийдвэр гүйлгээний 19,938,451.5 мянган төгрөгийн мэдээлэл байна.

Мэдээлээгүй, мөн дутуу мэдээлсэн 60,352,578.2 мянган төгрөгийн 193 мэдээлэл байгаа бөгөөд энэ нь нийт мэдээллийн 13.1 хувийг эзэлж байна.

Дээрх хүснэгтээс харахад: Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрууд 1,472 мэдээлэл мэдээлэхээс Баян-Өлгий аймаг 7, Баянхонгор аймаг 7, Булган аймаг 10, Говь-Алтай аймаг 6, Орхон аймаг 9, Сүхбаатар аймаг 13, Сэлэнгэ аймаг 15, Төв аймаг 14, Увс аймаг 5, Ховд аймаг 14, Хөвсгөл аймаг 9, Хэнтий аймаг 8, Багахангай дүүрэг 7, Баянгол дүүрэг 5, Баянзүрх дүүрэг 7, Налайх дүүрэг 11, Чингэлтэй дүүрэг 11 мэдээлэл мэдээлээгүй болон хугацаа хоцроож мэдээлсэн нь нийт мэдээллийн 10.7 хувийг эзэлж байна.

Мэдээлээгүй буюу хугацаа хоцроосон мэдээллийг мэдээллийн *төрлөөр* нь авч үзвэл:

Д/д	Шилэн дансны мэдээллийн төрлийн нэр	Нийт мэдээлэх	Мэдээлэл зохих		Мэдээлэл хугацаандаа оруулсан	Мэдээлэл оруулаагүй	Үүнээс:		Хугацаа хоцорсон мэдээлэл	Үүнээс:		Нийт мэдээлэл байршуулсан хувь	Хугацаандаа мэдээлэл байршуулсан хувь
			Шийдвэр, гүйлгээний тоо	Мөнгөн дүн			Шийдвэр, гүйлгээний тоо	Мэдээлэлгүй мөнгөн дүн		Шийдвэр, гүйлгээний тоо	Хугацаа хоцроосон мөнгөн дүн		
1	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-	96	96	25,964,951.7	92	1	1	1,001,431.9	3	3	511,048.0	99%	96%

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

	Эдийн засгийн ангилал												
2	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл-Хөтөлбөр, зориулалт	96	96	25,964,951.7	92	3	3	864,367.1	1	1	182,538.0	97%	96%
3	Байгууллагын батлагдсан төсөв	32	32	74,530,720.5	20	1	1	2,362,992.4	11	9	28,309,047.1	97%	63%
4	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	96	234	16,676,280.0	58	6	32	1,935,894.4	32	67	3,630,131.9	94%	60%
5	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	96	233	1,257,228.7	72	1	17	75,859.8	23	78	272,012.9	99%	75%
6	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	96	36	73,606,266.6	84	7	5	8,279,230.4	5	6	11,557,073.8	93%	88%
ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛ		512	727	218,000,399.2	418	19	59	14,519,776.0	75	164	44,461,851.7	96%	82%
1	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл	96	1	1,250.0	96	-	-	-	-	-	-	100%	100%
2	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	32	48	931,908.8	24	-	-	-	8	28	832,288.4	100%	75%
3	Худалдан авах ажиллагааны тайлан /2024 он/	32	68	912,355.5	30	1	-	-	1	1	53,778.0	97%	94%
4	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	96	283	685,015.0	54	24	70	169,396.5	18	41	125,812.2	75%	56%
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТЕНДЕР, ХУДАЛДАН АВАЛТ		384	400	2,530,529.3	332	25	70	169,396.5	27	70	1,011,878.6	93%	86%
1	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	96	-	-	83	8	-	-	5	4	1.0	92%	86%
2	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	96	128	1,933,947.5	64	3	10	35,534.3	29	59	154,140.1	97%	67%
3	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	96	3	50,848.5	96	-	-	-	-	-	-	100%	100%
4	Хавсралт файлууд	96	12	1,050.0	94	1	-	-	1	-	-	99%	98%
БУСАД		576	143	1,985,846.0	529	12	10	35,534.3	35	63	154,141.1	98%	92%
НИЙТ		1,472	1,270	222,516,774.5	1,279	56	139	14,724,706.8	137	297	45,627,871.4	96%	87%

Дээрх хүснэгтээс харахад: Нийт мэдээлээгүй буюу хугацаа хоцроосон мэдээллийн 48.7 хувь буюу 94 мэдээлэл нь **Төсөв, гүйцэтгэл** төрөлд, 26.94 хувь буюу 52 мэдээлэл нь **Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт** төрөлд, 24.35 хувь буюу 47 мэдээлэл нь **Бусад** төрөлд мэдээлэл нь мэдээлээгүй буюу хугацаа хоцроосон байна.

Төсөв, гүйцэтгэл төрөлд дараах мэдээллүүдийн хугацаандаа байршуулсан мэдээллийн хувь 60-75 хувьтай байна.

- Байгууллагын батлагдсан төсөв;
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ;
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ;

Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт төрөлд 56-75 хувьтай байна.

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө;
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;

Бусад төрөлд 67 хувьтай байна.

- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;

6. ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ

Хяналт шинжилгээгээр дараах нийтлэг алдаа зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Хэрэглэгчийн зүгээс мэдээллийг хугацаанд нь байршуулсан харагдах боловч доторх мэдээлэлд нэвтрэхэд мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, дутуу мэдээлсэн;
- Сарын мэдээ, батлагдсан төсөв, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг холбогдох ажилтны гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан тушаал шийдвэрийг хавсралт PDF, Excel файлаар байршуулаагүй;
- Сар бүр оруулах бодит мэдээлэл байхад мэдээллийг “Оруулах мэдээлэл байхгүй” төлвөөр мэдээлсэн;
- Байгууллагын үйл ажиллагаа болон сангийн мэдээллийг хооронд нь зөрүүлж мэдээлсэн;
- Мэдээллийг тухайн сард нь мэдээлээгүй дараа сард нь мэдээлсэн /4 дүгээр сарын мэдээлэх мэдээллийг 5 дугаар сард мэдээлэх гэх мэт;/
- И хуулгаас татагдаж байгаа мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавьж, мэдээллийг нягтлаагүй зэрэг алдаа, зөрчил байна.

Дээрх нийтлэг алдаа, зөрчил нь бүх аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газарт хамааралтай бөгөөд мэдээллийн төрөл тус бүрээр алдааг авч үзвэл:

- *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хөтөлбөр, зориулалт, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал төрөлд:*
 - ✓ Хэтрэлт, хэмнэлтийн шалтгааны тайлбарыг бичээгүй;
 - ✓ Эдийн засгийн ангилалын нэршлээр биш ангиллын кодоор мэдээлсэн;
 - ✓ Тухайн сарын мэдээ, мэдээллийг хавсралт файлаар мэдээлээгүй;
 - ✓ Орлого болон зарлагын төрлийг задлаагүй нийт дүнгээр мэдээлсэн;

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

- ✓ Орлого болон зарлагын төрлийг мэдээлсэн боловч нийт орлого, зарлагын дүнг мэдээлээгүй;
 - ✓ Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн жил, тайлант үе, тухайн сарын аль нэг дүнг мэдээлээгүй;
 - ✓ Байгууллагын төсөв, гүйцэтгэлийг нийт дүнгээр харах боломжгүй мэдээлсэн;
 - ✓ Хавсралт файлаар сарын мэдээний оронд И хуулга, төсвийн хэлбэлзлийг мэдээлсэн;
 - ✓ Хөтөлбөр зориулалт хоосон мэдээлсэн;
 - ✓ Хөтөлбөр зориулалтыг дансны дугаар, эдийн засгийн ангиллын кодоор (Эдийн засгийн ангиллын нэршлээр мэдээлээгүй) мэдээлж мэдээллийг хэрэглэгчдэд зориулаагүй байх;
- *Байгууллагын батлагдсан төсөв, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт төрөлд:*
- ✓ Батлагдсан төсвийг орлого, зарлагын нийт дүнгээр мэдээлсэн буюу орлого, зарлагын ангиллаар мэдээлээгүй;
 - ✓ Батлагдсан төсвийн нийт дүнг харах боломжгүйгээр мэдээлсэн;
 - ✓ Баталгаажсан шийдвэрийг хавсралтаар мэдээлээгүй;
 - ✓ Мэдээлэх бодит мэдээлэл байхад “оруулах мэдээлэл байхгүй” төлөвөөр мэдээлсэн;
 - ✓ Тухайн төсвийг бүрэн эхээр нь мэдээлэхгүйгээр зөрүүгээр мэдээлсэн;
 - ✓ Өөрчлөлт ороогүй саруудад батлагдсан төсвийг дахин мэдээлсэн;
 - ✓ Мэдээлсэн мэдээллийн мөнгөн дүн зөрүүтэй;
- *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ төрөлд:*
- ✓ Гүйлгээ хийснээс хойш тухай бүр мэдээлээгүй буюу сард 1 удаа мэдээлсэн;
 - ✓ Мэдээлэх бодит мэдээлэл байхад “оруулах мэдээлэл байхгүй” төлөвөөр мэдээлсэн;
 - ✓ 5 сая төгрөгөөс дээших орлого, зарлагын гүйлгээг тус бүрт нь бус нийт дүнгээр, өссөн дүнгээр мэдээлсэн;
 - ✓ Гүйлгээ хийгдсэн банк, харилцагч байгууллагын дансны нэр, дансны дугаар, гүйлгээний утга зэрэг бүрэн гүйцэд бичээгүй, хоосон байх, гүйлгээ хийсэн огноог буруу мэдээлсэн;
 - ✓ Орлого, зарлагын мөнгөн гүйлгээг хасах (-) тэмдгээр илэрхийлсэн;
 - ✓ Орлого, зарлагын мөнгөн гүйлгээг илүү мэдээлсэн;
 - ✓ Мэдээллийг мэдээлэхдээ даатгуулагчийн хувийн мэдээллийг нууцлахгүйгээр мэдээлсэн байх (Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авсан даатгуулагчийн регистрийн дугаар, овог нэр гэх мэт);
 - ✓ 5 сая төгрөгөөс дооших гүйлгээний мөнгөн дүнг мэдээлсэн;
 - ✓ Санхүүжилт, ташаарсан орлогыг мэдээлээгүй;
- *Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг төрөлд:*
- ✓ 5 сая төгрөгөөс дээш худалдан авалт хийх байгууллагатай хийсэн гэрээний дүнг мэдээлээгүй;
 - ✓ Худалдан авалт хийсэн сар бүрийн мөнгөн дүнг өссөн дүнгээр мэдээлээгүй;

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

- ✓ Мэдээлэх бодит мэдээлэл байхад “оруулах мэдээлэл байхгүй” төлөвөөр мэдээлсэн;
 - ✓ Газрын төлбөр, буцалтгүй тусламж зэрэг мэдээлэх ёсгүй мэдээллийг илүү мэдээлсэн;
 - ✓ Гүйлгээ хийсэн тухай бүр мэдээлээгүй;
- *Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт төрөлд:*
- ✓ Мэдээлэх бодит мэдээлэл байхад “оруулах мэдээлэл байхгүй” төлөвөөр мэдээлсэн;
- *Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр төрөлд:*
- ✓ Холбогдох газруудтай хийсэн гэрээг мэдээлээгүй;
 - ✓ Хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоогүй тушаал шийдвэрийг мэдээлсэн (ажилд томилсон, чөлөөлсөн, цалин шинэчлэн тогтоосон, цалинтай чөлөө олгосон тухай, мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох, ээлжийн амралт олгох тухай, Ёс зүйн хороо, эцэг эхийн зөвлөл, тооллогын комисс байгуулах тухай гэх мэт);
 - ✓ Энэ төрөлд мэдээлэх тушаал, шийдвэрийг “Бусад төрөл” цэсийн “Хавсралт файл” төрөлд мэдээлсэн;
 - ✓ Мэдээлэх бодит мэдээлэл байхад “оруулах мэдээлэл байхгүй” төлөвөөр мэдээлсэн;

Дээрх алдаа дутагдал нь мэдээллийн үнэн зөв, бодитой байх зарчмыг алдагдуулсан байна.

7. АВСАН АРГА ХЭМЖЭЭ, ЗӨВЛӨМЖ

Хяналт шинжилгээг хийх явцад дараах арга хэмжээг авч ажиллахын зэрэгцээ мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажиллалаа. Үүнд:

- Нийт мэдээлээгүй буюу 2,623 шийдвэр гүйлгээний 1,236,818.3 төгрөгийн мэдээллийг нөхөн мэдээлж зөрчлийг залруулж ажилласан.
- Мэдээлэл оруулах албан тушаалтан (Сангийн болон үйл ажиллагааны нягтлан бодогч), Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга нарыг мэргэжил арга зүйгээр ханган дахин илэрсэн алдаа, зөрчлийг гаргахгүй ажиллахыг анхааруулж зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн.

Мөн дээрх илэрсэн алдаа зөрчлийг залруулах явцад тухайн албан тушаалтнууд илэрсэн зөрчил, алдааг засварлахгүйгээр удах, олон удаа шаардуулах, илэрсэн алдааг ойлгохгүй мэдээллийг хооронд зөрүүлж ойлгох, дээд газраас хүргүүлсэн зөвлөмж чиглэлтэй танилцаагүй зэргээр цаг хугацаа алдах, мөн мэдээллийн зөвхөн “мэдээлэл оруулах хугацаа”-д анхаарал хандуулж мэдээлж буй мэдээллийн чанарт анхаарахгүй байна. Энэ нь мэдээллийн үнэн зөв, бодитой байх зарчмыг алдагдуулж байна.

8. ДҮГНЭЛТ:

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

8.1. Нийгмийн даатгалын байгууллагын болон нийгмийн даатгалын сангийн нийт 58,567 шийдвэр гүйлгээний 58,845,645.6 сая төгрөгийн 2,851 мэдээлэл байршуулахаас 2,567 мэдээллийг хугацаанд мэдээлж мэдээлэл байршуулалт 96 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 90 хувьтай байна.

Хяналт шинжилгээгээр нийт 22,260,030.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс:

- 2,655 шийдвэр гүйлгээний 16,746,532.2 сая төгрөгийн 101 мэдээллийг мэдээлээгүй;
- 1,311 шийдвэр гүйлгээний 2,842,952.6 сая төгрөгийн мэдээллийг илүү мэдээлсэн;
- 5,899 шийдвэр гүйлгээний 2,670,545.9 сая төгрөгийн 183 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн ба хугацаа хоцроож мэдээлсэн мэдээллээс хяналт шинжилгээний явцад зөрчлийг залруулж буюу нөхөн мэдээлсэн 2,623 шийдвэр гүйлгээний 1,236,818.3 сая төгрөгийн мэдээлэл байна.

Мэдээлээгүй, мөн дутуу мэдээлсэн 19,417,078.1 сая төгрөгийн 284 мэдээлэл байгаа бөгөөд энэ нь нийт мэдээллийн 10.0 хувийг эзэлж байна.

8.2. Шилэн дансны цахим хуудаст хугацаанд нь мэдээлэл байршуулалт хэрэглэгчийн зүгээс харахад 2025 оны эхний 03 сарын байдлаар мэдээлэл байршуулалт 100 хувь, хугацаандаа мэдээлэл байршуулалт 99 хувьтай мэдээлэгдэж харагдаж байгаа боловч хяналт шинжилгээний дүн мэдээнээс харахад мэдээлэл байршуулалт 96 хувь, хугацаандаа мэдээлэл байршуулалт 90 хувьтай байгаа нь доторх мэдээллийн үнэн зөв, бодитой, иж бүрэн, мэдээлэл ойлгомжтой байх зарчим алдагдаж мэдээллийн чанар хангалтгүй байгааг харуулж байна.

8.3. Нийгмийн даатгалын байгууллагын мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, бодитой мэдээлэх хувийг 100 хувьд хүргэх, мөн Баян-Өлгий, Булган, Баянхонгор, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Ховд, Хөвсгөл аймаг, Налайх, Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газар нь шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг байршуулахад онцгой анхаарах шаардлагатай байна.

8.4. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны “Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах тухай” 03 дугаар албан даалгавар, Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны “Шилэн дансны зөвлөмж хүргүүлэх тухай” 02/262 дугаар албан бичгээр хүргүүлсэн зөвлөмжтэй танилцаж үйл ажиллагаандаа хэрэгжүүлээгүй, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийх дотоодын хяналт, мэдээлэл оруулах ажилтнуудын ажлын хариуцлага, мэдлэг чадвар, ажилд хандах хандлага сул хэвээр байна.

8.5. Тус газраас Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны “Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах тухай” 03 дугаар албан даалгавар, мөн 2024 болон 2025 онд Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 2 удаагийн зөвлөмж, чиглэлийг хүргүүлсэн.

Харин хяналт шинжилгээгээр мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй, хугацаа хоцроох зэргээр өмнөх аудитаар илэрсэн зөрчил алдаанууд дахин давтагдан гарч байгаа нь Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, ажилтнуудын ажлын хариуцлагыг сайжруулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх, нэгжүүд цахим хуудсанд мэдээлэл байршуулах ажилд чиглэсэн арга хэмжээг “**Сайжруулах шаардлагатай**” гэж дүгнэж байна.

9. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

Хяналт шинжилгээгээр илэрсэн алдаа, зөрчилд дүгнэлт хийж, алдааг давтан гаргахгүй байх, ажилтнуудын ажлын хариуцлагыг сайжруулах, цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар дараах санал, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

9.1. Хуулийн хэрэгжилттэй холбоотой:

9.1.1. Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны “Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах тухай” 03 дугаар албан даалгавар, Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны “Шилэн дансны зөвлөмж хүргүүлэх тухай” 02/262 дугаар албан бичгээр хүргүүлсэн зөвлөмж, чиглэлийг сайтар уншиж, танилцах, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

9.1.2. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээ, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн хугацаанд стандарт, аргачлалын дагуу бүрэн байршуулах, байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулах;

9.1.3. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн шийдвэр, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг төрөл тухайн шийдвэр, гүйлгээ хийсэн тухай бүр мэдээллийг байршуулж хэвших;

9.1.4. Холбогдох мэдээлэлтэй холбоотой хавсралт файлыг тухай бүр тухайн төрөлд мэдээлэх;

9.1.5. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар заасан мэдээллийг мэдээлэхгүй байх;

9.1.6. Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ахлах нягтлан бодогч нар удирдлагадаа ажиллаж байгаа албан хаагчийг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах;

9.1.7. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт зааснаар газар болон албан тушаалтны ажлын тайланг дүгнэх гол үзүүлэлт нь энэ хуулийн хэрэгжилт болохыг анхаарах;

9.1.8. Ажилдаа хариуцлагагүй, хайнга хандсан Шилэн дансны тухай хууль тогтоомж зөрчсөн буюу мэдээлэл байршуулаагүй Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нар болон мэдээлэл оруулах үүрэг бүхий албан тушаалтнуудад Шилэн дансны тухай хуулийн 10.1 дэх хэсэг, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 9.1-д заасны дагуу хариуцлага тооцож ажиллах;

9.2. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны “Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах тухай” 03 дугаар албан даалгаврын биелэлттэй холбоотой:

9.2.1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын дотоод зохион байгуулалтын нэгжийн даргын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Шилэн дансны мэдээлэл байршуулахтай холбоотой арга хэмжээг тусгах;

9.2.2. Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан Мэдээлэх албан тушаалтан болох хүний нөөцийн мэргэжилтэн, үйл ажиллагааны нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолт болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд шилэн дансны мэдээлэл байршуулахтай холбоотой арга хэмжээг тусгах;

9.3.3. Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хэрэгжилтэд удирдлагаас тогтмол хяналт тавьж ажиллах;

9.3.4. Албан даалгаврын биелэлтийг улирал бүрийн дараа сарын 08-ны өдрийн дотор Дотоод аудит, мониторингийн газарт ирүүлж хэвших;

--oOo--

